

The background is a dark blue abstract design. It features a stylized globe on the left with glowing lines representing global connections. To the right of the globe, there are several circular icons containing currency symbols: the US dollar (\$), the Japanese yen (¥), the Bitcoin symbol (₿), and the Euro (€). These icons are interconnected by a network of glowing blue lines, suggesting a digital financial system or data flow. The overall aesthetic is modern and technological.

ТИПОЛОГИЙН ТАЙЛАН 2024

МӨНГӨН ГУЙВУУЛГЫН ҮЙЛЧИЛГЭЭ
АШИГЛАН МӨНГӨ УГААХ НЬ

Агуулга

I. ЗОРИЛГО	3
II. МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ, ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ ГЭМТ ХЭРЭГ БОЛОН МӨНГӨН ГУЙВУУЛГЫН ҮЙЛЧИЛГЭЭ	4
III. ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	6
3.1 Монгол Улсад	6
3.2 Олон улсад	7
IV. ХУУЛЬ ЁСНЫ МӨНГӨ, ҮНЭ БҮХИЙ ЗҮЙЛС ШИЛЖҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ 4.1 Монгол Улс дахь банкны гадаад гуйвуулгын үйлчилгээ.....	10
4.2 Монгол Улс дахь банк бус санхүүгийн байгууллагын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	13
V. МӨНГӨ, ҮНЭ БҮХИЙ ЗҮЙЛС ШИЛЖҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ	16
VI. ОЛОН УЛСЫН ТҮГЭЭМЭЛ ТИПОЛОГИУД.....	19
VII. КЕЙСҮҮД	22
VIII. ШИНЖ ТЭМДЭГ	29
8.1 Ерөнхий шинж тэмдгүүд.....	29
8.2 Гүйлгээтэй холбоотой шинж тэмдгүүд	30
8.3 Харилцагчийн мэдээлэлтэй холбоотой шинж тэмдгүүд.....	33
8.4 Харилцагчийн зан байдалтай холбоотой шинж тэмдгүүд	34
8.5 МҮБЗШҮ үзүүлэгч/МҮЭ/-д зориулсан шинж тэмдгүүд.....	34
IX. АВАХ АРГА ХЭМЖЭЭ	36
9.1 Эрсдэлд суурилсан арга хэмжээ	36
9.2 Сэжигтэй гүйлгээг илрүүлэх	37
9.3 Сэжигтэй гүйлгээний тайлангаар мэдээлэх	38

I. ЗОРИЛГО

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг нь дэлхий даяар улс орнуудын санхүүгийн системийн тогтвортой, найдвартай байдалд аюул, заналхийлэл учруулж байгаа бөгөөд НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газрын (UNODC) тооцоолсноор жил бүр дэлхийн ДНБ-ний 2-5 хувьтай тэнцэх хэмжээний мөнгө буюу 800 тэрбумаас 2 их наяд ам.доллар хүртэлх хэмжээний хууль бус, гэмт хэргийн замаар олсон мөнгийг угааж байна. Иймд Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг илүү өргөн хүрээнд тодорхойлж, сайтар ойлгох, улмаар эрсдэлийг бууруулах үр дүнтэй, оновчтой арга хэмжээ авч хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улс Үндэсний эрсдэлийн үнэлгээ (ҮЭҮ)-г тодорхой хугацааны давтамжтай хийж байгаа бөгөөд хоёр дахь удаагийн үнэлгээг 2021 онд хийж гүйцэтгэсэн.

СМА-ны зүгээс ҮЭҮ-ний үр дүнд суурилан мөнгө угаах гэмт хэргийн аюул занал, эрсдэл ӨНДӨР-тэй гэж үнэлэгдсэн суурь гэмт хэрэг, салбар, бүтээгдэхүүн үйлчилгээний мөнгө угаахтай холбогдох типологийн тайланг боловсруулж, холбогдох төрийн байгууллагууд болон мэдээлэх үүрэгтэй этгээдийн сонорт хүргэх, мэдээлэл өгөхийг зорьж байгаа болно. Үүний дагуу санхүүгийн байгууллага, тэр дундаа банк болон ББСБ-ын (эрсдэл өндөртэй салбар) мөнгөн гуйвуулгын болон гадаад валютын арилжааны үйлчилгээ (эрсдэл өндөртэй бүтээгдэхүүн, үйлчилгээ)-ний талаарх типологийн тайланг хийж гүйцэтгэв.


Энэхүү типологийн тайланг дараах зорилгоор боловсруулан гаргав. Үүнд:

1. Мэдээлэх үүрэгтэй этгээдэд мөнгөн гуйвуулгын үйлчилгээг ашиглан мөнгө угаах гэмт хэрэг үйлдэх арга хэлбэрийн талаар ойлголт өгөх, тэдгээрийг таньж мэдэх, илрүүлэх, хэрхэн зогсоох арга хэмжээ авах талаар мэдлэг, мэдээлэл өгөх;
2. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэгчид хяналт тавихад туслах;
3. Мэдээлэх үүрэгтэй этгээд болон мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэгчид хууль бус мөнгөн гуйвуулгын үйлчилгээг таних, холбогдох арга хэмжээ авах.

II. МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ, ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ ГЭМТ ХЭРЭГ БОЛОН МӨНГӨН ГУЙВУУЛГЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх гэмт хэрэгт болон эдгээр гэмт хэргийн үе шат бүрд хэрхэн ашиглагдаж болохыг дараах байдлаар харуулав. Үүнд:

Зураг 1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үе шат



Нэгдүгээр үе шатны гол онцлог нь бэлэн мөнгө байдаг. Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ нь бэлэн мөнгийг санхүүгийн системд оруулахад тохиромжтой байдаг бол хоёрдугаар үе шатанд уламжлалт банкыг ашиглах нь тодорхой ул мөрөө үлдээж байдаг. Харин мөнгөн гуйвуулга /хавала гэх мэт/ ашиглах нь богино хугацаанд албан бус мэдээлэл үлдээн, эх үүсвэрийг илүү сайн нуух боломжтой. Гуравдугаар үе шатны гол зорилго болох хууль бус орлогыг (терроризмыг санхүүжүүлэхэд хууль ёсны орлого ч ашиглаж болно) нэгтгэхэд мөнгөн гуйвуулгын үйлчилгээ /хавала гэх мэт/ нь тохиромжтой, тухайн мөнгийг хууль ёсны мэт харагдуулж чаддаг.

*Иймд мөнгөн гуйвуулгын үйлчилгээ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн үе шат бүрд ашиглагдаж болзошгүй байна.

Зураг 2. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх үе шат



Нэг, хоёрдугаар үе шатанд уламжлалт банкыг ашиглах нь тодорхой ул мөрөө үлдээж байдаг, харин мөнгөн гуйвуулга/хавала гэх мэт/ ашиглах нь богино хугацаанд албан бус мэдээлэл үлдээн, эх үүсвэрийг илүү сайн нуух боломжтой. Харин гуравдугаар үе шатанд эх үүсвэрийг цэвэршүүлсэн мөнгөөр худалдан авалтыг хийх нь түгээмэл байдаг.

*Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх гэмт хэргийн эхний 2 үе шатанд мөнгөн гуйвуулгын үйлчилгээг ашиглах нь түгээмэл байна.

III. ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

3.1 Монгол Улсад

Монгол Улсад 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т заасны дагуу мөнгөн гуйвуулгын үйлчилгээг тус хуулийн 2.1-т заасан банк, 2.10-т заасан банк бус санхүүгийн цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн дагуу Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд явуулах эрхтэй байдаг. Энэхүү тусгай зөвшөөрлийн дагуу банк нь Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-т заасны дагуу төлбөр тооцооны үйлчилгээ; 6.1.8-д заасны дагуу гадаад төлбөр тооцоо хийх гэсэн үйл ажиллагааны хүрээнд, банк бус санхүүгийн байгууллага нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-т заасны дагуу цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний хүрээнд тус тус явуулна. (2016 оноос хойшх олон улсын баримт бичгүүд болон ФАТФ-ын зөвлөмжид “Money or value transfer services (MVTs)” (1,10,14,16,29) буюу Мөнгө, үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ (МҮБЗШҮ) гэж тодорхойлсон тул цаашид энэ нэршлийг ашиглав.)

Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн мэдээлэлд 2021-2023 онд “мөнгө угаах” төрлийн 16 хэргийг шийдвэрлэсэн боловч эдгээрээс мөнгөн гуйвуулгын үйлчилгээг ашиглан үйлдэгдсэн мөнгө угаах, эдийн засгийн болон авлигын гэмт хэрэг бүртгэгдээгүй, шүүхээр шийдвэрлэгдээгүй байна. Энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгалтаар нотлох нь цаг хугацаа, механик ажиллагаа их шаарддагаас гадна хоорондын холбоосыг тогтооход хүндрэлтэй байдаг. МҮБЗШҮ ашиглан мөнгө угаах нь ИБУИНВУ, БНСУ, Австрали, АНУ, Европын холбооны улсууд зэрэг Монгол Улсын иргэд олноор ажиллаж амьдардаг улсуудад үйлдэгдэх магадлал өндөртэй, манай улсын иргэдийг ашиглан тухайн улсад нь болон Монгол Улсад мөнгө угаах, солилцох, хөрвүүлэх хэлбэрээр гэмт хэрэг үйлдэгдэх эрсдэл үүсэх боломжтой байна гэжээ.

Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэлд сүүлийн жилүүдэд манай улсын иргэд, аж ахуй нэгжүүд хөрөнгө оруулалт, хамтран ажиллах гэрээгээр халхавчлан гадаад улсаас эх үүсвэр нь тодорхойгүй их хэмжээний мөнгө хөрөнгө шилжүүлэн авч үйл ажиллагаандаа ашиглах, үнэтэй эд хөрөнгө худалдаж авах, банк, санхүүгийн байгууллагаар дамжуулан өөр улс руу гадаад шилжүүлэг хийх зэрэг мөнгөн гуйвуулгын шилжүүлгүүд огцом ихсэх хандлагатай байна гэжээ.

Хууль сахиулах байгууллагаас ирүүлсэн дээрх мэдээллээс харахад мөнгөн гуйвуулгын үйлчилгээг ашиглан үйлдэгдсэн гэмт хэргийн статистик тоо баримт бүртгэгдээгүй бөгөөд энэ төрлийн үйлчилгээг ашиглан гэмт хэрэг үйлдэх нь тухайн хэргийг илрүүлэх болон мөрдөн шалгах үйл ажиллагааг илүү төвөгтэй болгодог байна.

Тусгай зөвшөөрлийн дагуу мөнгөн гуйвуулгын үйл ажиллагаа явуулахад тусгайлан тавигддаг шаардлага байхгүй бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын

журмын 2(б) дугаар хавсралтад заасан банк бус санхүүгийн үйл ажиллагаа нэмж эрхлэх зөвшөөрөл авах өргөдөл (маягт сэх 02001), хавсаргах баримт бичгийн жагсаалтад заасны дагуу материал ирүүлдэг байна.

Дээр заасан хууль, журмын дагуу тусгай зөвшөөрөл авалгүйгээр мөнгөн гуйвуулгын үйл ажиллагааг явуулж байгаа аливаа хувь хүн, хуулийн этгээдийг хууль бус гэж үзэн холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авна.

Санхүүгийн зохицуулах хорооны тоон мэдээллээс дурдвал 2024 оны I улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 47 ББСБ байгаа ба нийт активын 25.4 хувийг бүрдүүлж байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д зааснаар “цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ” гэж бусдын мөнгөн хөрөнгийг банкн дахь өөрийн харилцах дансаар дамжуулан шилжүүлэх, эсхүл интернэт, автомат тоног төхөөрөмж, цахим төлбөр тооцооны хэрэгсэл ашиглаж, төлбөр тооцоог нь гүйцэтгэх ажиллагааг ойлгоно” гэсэн байна. Үүний дагуу ББСБ нь олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг үзүүлэхдээ өөр өөр хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг байна. Үүнд: i) харилцагчийн гуйвуулга бүрийг арилжааны банкаар дамжуулан шилжүүлдэг, ii) МҮБЗШҮ үзүүлэгч байгууллагууд нь харилцагчийн гуйвуулгыг зөвхөн бүртгэл хэлбэрээр хөтөлж, тухайн шилжүүлгийн талаар мессеж явуулдаг. Тодорхой хугацааны дараа зөвхөн данс цэнэглэх зорилгоор банкаар дамжуулан шилжүүлгийн гүйлгээ хийдэг.

Мөн Санхүүгийн зохицуулах хорооноос энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлэгчид газар дээрх хяналт шалгалт хийх үед мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах заалтын дагуу шалгадаг бөгөөд харилцагчийг таньж мэдэх, мэдээлэх үүргийн хэрэгжилтийг тусгайлан хянан шалгадаг. Шалгалтын явцад харилцагчийг таних талаарх тусгайлан журамтай эсэх, энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрддөг эсэх, баримт бичгийн бүрдүүлэлт, хуульд заасан гүйлгээг СМА-нд мэдээлдэг эсэхийг шалгах, харилцах данс болон бэлэн мөнгөний тайланг тайлант хугацаагаар тулган шалгах ажиллагаанууд хийгддэг.

3.2 Олон улсад

Мөнгөн гуйвуулгын үйлчилгээг дотоод болон гадаад гэж ангилдаг бөгөөд энэхүү тайланд гадаад мөнгөн гуйвуулгын үйлчилгээг авч үзсэн болно.

Олон улсад мөнгөн гуйвуулгын үйлчилгээ буюу түүнтэй ижил төстэй үйл ажиллагааг явуулж буй хэлбэрээс нь хамааруулан хэд хэдэн нэршлээр нэрлэсэн байна. 2005 оны ФАТФ-аас гаргасан “Money laundering and terrorist financing typologies” гэсэн баримт бичигт “Alternative remittance system”, 2013 онд ФАТФ-аас гаргасан “The role of hawala and other similar service providers in money laundering and terrorist financing” гэсэн тайланд “Hawala and Other Similar Service Provider” гэх мэт. Гэвч 2016 оноос хойших баримт бичгүүд болон ФАТФ-ын зөвлөмжид “Money or value transfer services (MVTs)” (1,10,14,16,29) буюу **Мөнгө, үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ** гэж тодорхойлсон тул цаашид энэ нэршлийг ашиглав.

Нэмж дурдахад олон улсын зөвлөмжийн дагуу виртуал хөрөнгийн шилжүүлэг нь мөнгөн гуйвуулгын шилжүүлэг гэсэн ойлголтод хамаарахаар заасан боловч Монгол Улсад тус тусын эрх зүйн баримт бичгийн дагуу зохицуулагдаж байна. Тиймээс энэхүү типологийн тайланд виртуал хөрөнгийн шилжүүлгийг авч үзээгүй болно.

Мөнгө, үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээнд (МҮБЗШҮ) бэлэн мөнгө, чек, бусад төлбөрийн хэрэгсэл эсвэл бусад үнэ бүхий хэрэгсэл хүлээн авч, шилжүүлэг хүлээн авагчид бэлэн мөнгөөр болон бусад хэрэгслээр харилцаа холбоо, мэдээлэл, МҮБЗШҮ үзүүлэгчийн харьяалагддаг төлбөр тооцооны клирингийн сүлжээг ашиглан шилжүүлгийг хийдэг санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид орно. Энэ төрлийн үйлчилгээнд нэг буюу түүнээс дээш зуучлагчид оролцож болох бөгөөд эцсийн төлбөр тооцоог гуравдагч этгээдэд төлөхдөө шинэ төрлийн төлбөрийн арга хэрэгслийг ашиглаж болно.

Заримдаа эдгээр үйлчилгээнүүд нь тодорхой газар зүйн бүс нутагт харьяалагдаж хавала, хинди, фей-чен зэрэг өөр өөрөөр нэрлэсэн байдаг.¹

Улс орнууд нь МҮБЗШҮ үзүүлэгчийн төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэж байгаа аливаа хувь хүн, агент болон хуулийн этгээдийг мөн адил эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл олгох эсвэл бүртгэлд хамруулдаг.

ФАТФ-ын зөвлөмжийн дагуу улс орнууд зөвшөөрөл эзэмшдэг эсвэл бүртгэгдсэн МҮБЗШҮ үзүүлж байгаа хувь хүн болон хуулийн этгээдийг зөвлөмжид тусгасан холбогдох заалтыг биелүүлж байгаа эсэхэд хяналт шалгалтын арга хэмжээ авахыг шаарддаг. Мөн тусгай зөвшөөрөлгүй, бүртгэлгүй МҮБЗШҮ эрхэлж байгаа хувь хүн болон хуулийн этгээдийг илрүүлж, тохирох шийтгэлийн арга хэмжээ авах шаардлагатай. Эсвэл МҮБЗШҮ үзүүлэгч нь өөрийн төлөөлөгчийн жагсаалтыг тухайн үйл ажиллагаа явуулж байгаа улс орны болон төлөөлөгчдийн үйл ажиллагаа явуулж байгаа улс орны эрх бүхий байгууллагад гаргаж өгөхөд бэлэн байлгах шаардлагатай. Өөр улс орнуудад төлөөлөгчөөр дамжуулан үйл ажиллагаа явуулдаг МҮБЗШҮ үзүүлэгчид нь өөрийн төлөөлөгчдийг МУТСТ хөтөлбөрт хамруулж, биелэлтийг хангуулах арга хэмжээ авч байгааг хянах шаардлагатай.²

ФАТФ зөвлөмж 14 болон 26-д зааснаар Мөнгө, үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ (МҮБЗШҮ) үзүүлэгч нь хувь хүн болон хуулийн этгээд байж болно³.

МҮБЗШҮ үзүүлэх үйл ажиллагаа нь маш олон төрлийн байгууллагуудаас бүрддэг. Тэдгээр нь хүнсний дэлгүүр, эмийн сан, эмийн сан, хүнсний дэлгүүр гэх мэт мөн хязгаарлагдмал цэг бүхий жижиг байгууллага байж болно. Үүнд салбар, төлөөлөгч байж болох шуудангийн салбар, банк эсвэл бусад байгууллагуудын бүс нутгийн сүлжээ багтаж болно. Ихэнхдээ зөвшөөрөлтэй эсвэл бүртгэлтэй МҮБЗШҮ үзүүлэгчид нь шилжүүлэг

¹ ФАТФ-ийн зөвлөмжийн тайлбар хэсгээс

² Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг

санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт


<https://www.mongolbank.mn/file/files/documents/cma-20180531F2.pdf>

³ Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандартын зөвлөмж 16-ийн тайлбар хэсгээс

хийх, дотоод болон олон улсын агентуудтай харилцах данстай байхын тулд банканд данс эзэмшдэг. Гэсэн хэдий ч төлбөр тооцоог олон улсын банкны системээр дамжсан мөнгөн шилжүүлгээр хийж болно. Мөн төлбөр тооцоог гуравдагч этгээдийн төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан хийж болно.⁴

Төлөөлөгчийн газар гэдэг нь : МҮБЗШҮ үзүүлэгчийн удирдлагаар гэрээний дагуу мөнгө, үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээг үзүүлдэг хувь хүн болон хуулийн этгээдийг хэлнэ.

Зураг 3. Мөнгөн шилжүүлэг хийх явц



Цахим шилжүүлэг гэдэг нь шилжүүлэгч хувь хүн болон хуулийн этгээдийн өмнөөс санхүүгийн байгууллагаар дамжуулан хүлээн авагчийн санхүүгийн байгууллагад цахимаар дамжуулахыг хэлнэ. Үүнд хүлээн авагч болон шилжүүлэгч нь нэг хүн байж болно.⁵

⁴ Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандартын зөвлөмж 14

⁵ Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандартын зөвлөмж 16-ийн тайлбар хэсгээс

IV. ХУУЛЬ ЁСНЫ МӨНГӨ, ҮНЭ БҮХИЙ ЗҮЙЛС ШИЛЖҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ

МҮБЗШҮ-г маш олон төрлийн байгууллага үзүүлж болно. Бүх төрлийн МҮБЗШҮ үзүүлэгч нь ижилхэн хэмжээний бүтэцтэй, ижил төрлийн байгууллага байх боломжгүй, жижиг байгууллагаас эхлээд олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг том корпорацийн түвшинд ч байж болно. Үйлчилгээ үзүүлэгчид нь олон улсад МҮБЗШҮ үзүүлэгч, шуудангийн газар, бичил санхүүгийн байгууллага, үүрэн холбооны оператор⁶, валют солих газар, төлбөрийн байгууллага⁷, эскроу дансны үйлчилгээ, төлбөр тооцоо, мэдээллийн технологийн болон дижитал төлбөрийн үйлчилгээ, мөнгө шилжүүлгийн операторууд байж болно. Мөн МҮБЗШҮ үзүүлэгчид нь ихэвчлэн жижиглэн худалдаа, худалдааны болон бөөний чиглэлээр мэргэшсэн байгууллага байдаг. Монгол Улсад МҮБЗШҮ-г үзүүлэх зөвшөөрөлтэй дараах 2 төрлийн байгууллага байдаг. Үүнд:

1. **Банк** - Иргэдээс хадгаламж болон бусад эргэн төлөгдөх хөрөнгийг хүлээн авах зээл олгох; төлбөрийн хэрэгсэл гаргах буюу удирдах⁸ зэрэг банкны үйлчилгээ үзүүлдэг санхүүгийн байгууллагууд үзүүлж болно;
2. **Банк бус санхүүгийн байгууллага** - Хуулийн этгээд МҮБЗШҮ-г бизнес хэлбэрээр, тэр дундаа агентууд эсвэл сүлжээгээр дамжуулан, ихэнхдээ олон нийтээс хадгаламж болон бусад эргэн төлөгдөх хөрөнгийг хүлээн авахгүйгээр үзүүлэх. Олон МҮБЗШҮ үзүүлэгчид дээрх системээр дамжуулан төвлөрсөн данс болон дэд дансаар дамжуулан эсвэл үйлчилгээ үзүүлэгчийн эзэмшдэг төвлөрсөн банкны данс болон МҮБЗШҮ-ийн төлөөлөгчдийн эзэмшдэг хувийн банкны дансны хооронд төлбөр тооцоо хийх замаар агентуудтай тооцоо хийж болно. Олон улсад МҮБЗШҮ-ний тодорхойлолтод виртуал валют солилцогчдыг хамааруулдаг.

4.1 Монгол Улс дахь банкны гадаад гуйвуулгын үйлчилгээ

Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг бүх банкууд гадаад шилжүүлгийн үйлчилгээг төрөл бүрийн сувгаар дамжуулан үзүүлж байна. Эдгээрээс системийн нөлөө бүхий 5 банкыг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:



ХААН БАНК

Солонгос Улсаас Монгол Улс руу ам.доллар, төгрөгийн шилжүүлэг хийх, 5 төрлийн валютаар бусад улс орноос шилжүүлэг хийх, хүлээн авах, Western Union-оор дэлхийн бүх улсуудад ам.доллараар шилжүүлэг хийх зэрэг мөнгөн гуйвуулгын үйлчилгээг,⁹

⁶ Үүрэн телефоны операторууд.

⁷ Банк болон санхүүгийн байгууллагатай зэрэгцэн төлбөрийг үйлчилгээг үзүүлдэг байгууллагууд.

⁸ Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандартын тайлбар, “санхүүгийн байгууллага” хэсгээс

⁹ <https://khanbank.com/>,



Виза карт хооронд, СВИФТ сүлжээгээр дамжуулан 14 төрлийн валютаар шилжүүлэг хийх, Western Union-оор дэлхийн бүх улсуудад ам.доллараар шилжүүлэг хийх зэрэг мөнгөн гуйвуулгын үйлчилгээг,¹⁰



СВИФТ сүлжээ, Western Union сүлжээгээр дамжуулан дэлхийн бүх улсуудад мөнгөн гуйвуулгын үйлчилгээг,¹¹



Виза карт хооронд, QBC - Япон Улсаас Монгол Улсад иен хүлээн авах, Pay Easy- Солонгос Улсаас Монгол Улс руу ам.долларын шилжүүлэг хийх, СВИФТ - 31 төрлийн валютаар шилжүүлж, 15 төрлийн валютаар хүлээн авах, MoneyGram – 200 гаруй улсын 350.000 гаруй үйлчилгээний цэгүүдээр дамжуулан мөнгө шилжүүлэх, хүлээн авах гэх мэт мөнгөн гуйвуулгын төрөл бүрийн үйлчилгээг,¹²



СВИФТ сүлжээг ашиглан 11 төрлийн валютаар бүх улс орнуудаас шилжүүлэг хүлээн авах, шилжүүлгийг тус тус хийдэг.

¹⁰ <https://golomtbank.com/>,

¹¹ <https://www.statebank.mn/>,

¹² <https://tdbm.mn/mn/>,

МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГААС...

“Мөнгө угаах гэмт хэргээр мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлсэн, яллах дүгнэлт үйлдсэн болон шүүхийн шийтгэх тогтоол гаргасан тохиолдлуудаас харахад 58 хувийг банкны салбарыг ашигласан тохиолдлууд бүртгэгджээ. Банкны салбар ийнхүү талаас илүү хувийг эзэлж байгаа нь Монгол Улсын санхүүгийн системийн 90 гаруй хувийг тус салбар эзэлж байгаатай холбоотой. Өөрөөр хэлбэл, манай улсын санхүү, эдийн засгийн системээр дамжин эргэлдэж буй нийт мөнгөн хөрөнгийн 90 гаруй хувь нь банкны салбараар дамжиж байгаа нь энэ салбарыг мөнгө угаах гэмт хэргийн аюул заналд илүү өртөмтгий болгож байна. Мөнгө угаах гэмт хэргээр мөрдөн шалгах, яллах болон шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлсэн тохиолдлуудын 58 хувьд банкны салбарыг ашиглажээ. Үүнийг дагаад мөнгө угаах гэмт хэргийн эрсдэлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээний тоонд банкны салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээ буюу цахим мөнгөн гуйвуулгын үйлчилгээ ашиглагдах хамгийн өндөр эрсдэлтэй гэсэн тооцоолол гарлаа.

Банкны салбарыг ашигласан гэдэгт аливаа хууль бус болон эх үүсвэр нь тодорхойгүй мөнгөн хөрөнгийг банкны салбарт байршуулсан, эсхүл түүний эх үүсвэрийг нуун дарагдуулах болон хэлбэрийг хувиргах цаашлаад зугтаалгах зорилгоор банкны салбараар дамжуулан гүйлгээ хийсэн тохиолдлууд багтаж байгаа болно.

Мөнгө угаах гэмт хэргийн үйлдэгдэх үе шат тус бүрт банкны салбарын бүтээгдэхүүн үйлчилгээг хэрхэн ашиглаж байгааг задлан шинжилбэл: Гадаад улсаас гаралтай хууль бус эсхүл эх үүсвэр нь тодорхойгүй мөнгөн хөрөнгийг мөрдөн шалгаж байгаа тохиолдлуудад дийлэнхдээ хөрөнгө оруулалт эсхүл зээл хэлбэрээр холбогдох мөнгөн хөрөнгө нь SWIFT гүйлгээний системээр дамжин банкны салбарт байршиж байна...

... Харин мөнгө угаах гэмт хэргийн хувиргах шатанд хууль бус эсхүл эх үүсвэр нь тодорхойгүй мөнгөн хөрөнгийн хэлбэрийг валют арилжаанд эргэлдүүлэх, гүйлгээний утгыг жишээлбэл “бараа бүтээгдэхүүний худалдан авалт” гэсэн байдлаар хуурамчаар үйлдэж, аливаа хууль ёсны бизнесийн үйл ажиллагаанаас олсон ашиг мэт харагдуулах байдлаар тухайн мөнгөн хөрөнгийн хэлбэрийг **банкны мөнгөн гуйвуулгын үйлчилгээг** ашиглан өөрчилж байна. Үүнээс гадна их хэмжээний мөнгөн хөрөнгийг МУТСТ чиг үүрэг бүхий төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын хараа, хяналтаас бултуулах зорилгоор эдийн засгийн үндэслэлгүйгээр олон хэсэгт жижиглэн хувааснаар шилжүүлж буй тохиолдлууд мөрдөн шалгах ажиллагааны явцад бүртгэгдэж байсан болно. Мөн гэмт этгээд нь гэмт хэрэгт хамааралгүй бусад этгээдийн дансыг тэдгээрт шан харамж өгөх байдлаар ашиглаж, аливаа мөнгөн хөрөнгийг шилжүүлж байсан тохиолдлууд мөрдөн шалгах ажиллагааны явцад бүртгэгдсэн.

Хувиргах үе шатанд дийлэнх тохиолдолд SWIFT гүйлгээний системийг ашиглан зугтаалгах, эсхүл хэд хэдэн данс руу шилжүүлэх, бэлнээр зарлагдах гэх мэт байдлаар ул мөрийг баллах буюу гүйлгээний утгыг хуурамчаар шивж, банкны теллерүүдэд худал мэдээлэл өгч буй тохиолдлууд бүртгэгдсэн.

Иймд Монгол Улсын санхүүгийн системээр эргэлдэж буй нийт мөнгөн хөрөнгийн 95 гаруй хувь нь банкны салбараар дамжиж байгаа ч тус салбар нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээрх өөрсдийн хяналт, шалгалтын үйл ажиллагаагаа олон улсын түвшинд нийцүүлэн хөгжүүлснийг үндэслэн тухайн салбарыг ашиглан мөнгө угаах гэмт хэргийг үйлдэх аюул, заналыг **ӨНДӨР** хэмээн үнэлэх нь зүйтэй.”

4.2 Монгол Улс дахь банк бус санхүүгийн байгууллагын мөнгөн гүйвүүлгын үйлчилгээ

Монгол Улсад банкнаас өөр МҮБЗШҮ үзүүлэгч байгууллага нь банк бус санхүүгийн байгууллага юм. Энэ төрлийн үйлчилгээ үзүүлэгчдийн хэмжээ, нарийн төвөгтэй байдал ихээхэн ялгаатай бөгөөд янз бүрийн бизнесийн загваруудыг ашигладаг байна.

Банк бус санхүүгийн байгууллагын үзүүлдэг МҮБЗШҮ нь банктай харьцуулахад дараах онцлог шинж чанартай байдаг. Үүнд:

- Хямд сонголт – Банктай харьцуулахад санхүүгийн үйлчилгээг бага зардлаар хүргэж байгаа тул харилцагчид энэ төрлийг үйлчилгээнд дуртай байдаг,
- МҮБЗШҮ үзүүлэгчид нь олон янзаар үйл ажиллагаа явуулдаг боловч ихэвчлэн мөнгөн шилжүүлгийг хүлээн авч, шаардлагатай мэдээллийг цуглуулж, гүйлгээ хийж, шилжүүлэгч болон хүлээн авагчийн мэдээллийг бүртгэн, шилжүүлэг хийдэг,
- Мөнгөн шилжүүлгийн хувьд МҮБЗШҮ үзүүлэгчид нь тухайн шилжүүлгийн хүлээн авагчид мөнгө буюу түүнтэй тэнцэх хэмжээний валютыг олгох талаар төлбөрийн дэлгэрэнгүй мэдээллийг гэрээт хуулийн этгээд/төлбөрийн агент руу шилжүүлдэг. Тухайн мессежийг гэрээт хуулийн этгээд/агентууд руу шууд илгээдэг эсвэл үйлчилгээ үзүүлэгчийн янз бүрийн агентуудыг холбосон мэдээллийн төвлөрсөн төв буюу төвлөрсөн тооцооны аппликэшнээр дамжуулан илгээдэг,
- Мөнгө шилжүүлэх үйл явц нь харьцангуй хурдан байдаг,
- Ихэнхдээ төлбөр шилжүүлэгч нь зохих мөнгөн тэмдэгтийг хүлээн авагч МҮБЗШҮ болон агент (мөн МҮБЗШҮ үзүүлэгчийн нэрийн өмнөөс ажиллаж байгаа) дээр өгч, нууцлал бүхий мэдээллийг хүлээн авна. Энэхүү нууцлал бүхий мэдээлэлд үндэслэн хүлээн авагч нь тухайн өөрийн улсын холбогдох МҮБЗШҮ үзүүлэгч дээр очиж шаардлагатай таних мэдээллийг үзүүлэн баталгаажуулна.

HOSSP буюу Хавала болон бусад ижил төрлийн үйлчилгээ үзүүлэгч (ХББҮҮ гэх) нь урт хугацааны туршид худалдаа, бэлэн мөнгө болон/эсвэл цэвэр төлбөр тооцоогоор хийгдэх мөнгө буюу түүнтэй адилтгах үнэ бүхий зүйлийг шилжүүлэх, хүлээн авах ажлыг зохион байгуулдаг, ялангуяа газарзүйн тодорхой бүс нутаг эсвэл тодорхой бүлэгтэй холбоотой МҮБЗШҮ үзүүлдэг байгууллагуудыг нэрлэдэг.

Зураг 4. Хавала болон бусад ижил төрлийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн дэвтэр¹³

16/6/98 Vinod 100000 37.6 2659.57 F-1202
16/6/98 Ashish 250000 39.25 6369.42 F-1203
16/6/98 Nitin Bhai 350000 42.3 8274.23 B-8146
17/6/98 DK 50000 38.75 1290.32 F-1204
17/6/98 Suresh Kumar 300000 39.25 7643.31 B-8147
17/6/98 Anil 200000 40.1 4987.53 S-5428
17/6/98 Vinod 150000 39.75 3773.58 F-1205
18/6/98 Manoj 300000 41.25 7272.72 B-8148
18/6/98 Vinod Bhai 350000 42.2 8293.83 L-2160
18/6/98 Ganesh Trading 200000 38 5263.15
19/6/98 Suresh Kumar 175000 39.5 4430.37 B-8149

¹³ Siddiqui, Danish Ahmed, Alternative Remittance Systems and Its Impact on Money Laundering (August 23, 2004). Available at SRN: <https://ssrn.com/abstract=3271778> or <http://dx.doi.org/10.2139/ssrn.3271778>

МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГААС...

2017-2019 онуудад мөнгө угаах гэмт хэргээр мөрдөн шалгах, яллах болон шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлсэн тохиолдлуудын 17%-д нь банк бус санхүүгийн байгууллагын бүтээгдэхүүн үйлчилгээ ашигласан байх бөгөөд үүнд банк бус санхүүгийн байгууллагын **мөнгөн гуйвуулга болон валют арилжааны үйлчилгээнүүд** түлхүү хамаарч байгаа болно.

Гадаадын хөрөнгө оруулалттай 27 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд ихэвчлэн БНСУ, Япон улсын хөрөнгө оруулалттай байна. Салбарын зах зээлийн идэвхжил, эрэлт нийлүүлэлтээс хамааран хувьцаат компани болсон 4 ББСБ, санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, онлайн зээлийн үйлчилгээ үзүүлж буй 10 ББСБ байна.

Дийлэнх банк бус байгууллагуудын **мөнгөн гуйвуулгын үйлчилгээ** нь арилжааны банкуудаар дамжин хийгдэж байгаа нь тухайн салбарын эрсдэлийг мөн банкны салбарт давхар хамруулах нэг талаараа зүйтэй гэж үзлээ.

Мөрдөн шалгах чиг үүрэг бүхий **байгууллагуудын** туршлагаас харахад хууль бус эсхүл эх үүсвэр нь тодорхойгүй мөнгөн хөрөнгийг эхний ээлжинд ББСБ-ын **мөнгөн гуйвуулгын үйлчилгээ буюу албан бус гүйлгээний (hawala) системийг** ашиглан Монгол Улсын санхүүгийн системд байршуулж буй тохиолдлууд дийлэнхдээ бүртгэгдэж байна.

Дээрх албан бус мөнгөн гуйвуулгын системийг ашигласнаар аливаа банк бус байгууллагын дансанд байршуулагдсан мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийн талаарх мэдээлэл бүртгэгдэж үлддэггүй нь санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны хүрээнд аливаа иргэн, хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг тогтооход хүндрэл, бэрхшээл учруулдаг.

Харин аливаа мөнгөн хөрөнгийн хэлбэрийг өөрчилж валют арилжаанд оруулах эсхүл гадаад улс руу зугтаалгах тохиолдолд үүнийг банк бус санхүүгийн салбараар дамжуулан үйлдэх нь мөн адил аливаа ул мөр бүртгэгдэж үлдэхгүй бөгөөд энэ нь мэдээж санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны хүрээнд тодорхой хүндрэл, бэрхшээл учруулдаг болно.

Иймд тус банк бус санхүүгийн салбараар дамжуулан аливаа хууль бус эсхүл эх үүсвэр нь тодорхойгүй мөнгөн хөрөнгийг валют арилжаа, **мөнгөн гуйвуулгын үйлчилгээнд** оруулсан тохиолдолд энэхүү үйлдэл нь дансны хуулга гэх мэт бусад бүртгэлийн чанартай материалуудад бүртгэгдэхгүй байгаа зэргийг үндэслэн тухайн салбарыг ашиглан мөнгө угаах гэмт хэргийг үйлдэх аюул заналыг **ӨНДӨР** хэмээн үзэх нь зүйтэй.

V. МӨНГӨ, ҮНЭ БҮХИЙ ЗҮЙЛС ШИЛЖҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ

ФАТФ-аас гаргасан Зөвлөмж 14-ийн дагуу улс орнууд нь хууль бус, зөвшөөрөлгүй МҮБЗШҮ үзүүлэгчдийг тодорхойлох зорилгоор системтэй, урьдчилсан арга хэмжээнүүдийг авах шаардлагатай. Хууль бус, зөвшөөрөлгүй МҮБЗШҮ үзүүлэгчдийн үйл ажиллагааг тодорхойлоход дараах мэдээллийн эх үүсвэрүүд нь хэрэг болж болзошгүй. Үүнд:


- Тусгай зөвшөөрөл хүссэн, бүртгүүлэх хүсэлтүүд, түүнчлэн амжилтгүй болсон, дахин давтан гаргасан хүсэлтүүд,
- МҮБЗШҮ үзүүлэгч нарын маркетингийн үйл ажиллагаа, хэвлэлийн хэрэгслүүдээр гарч буй олон төрлийн зар сурталчилгаа,
- Сэжигтэй гүйлгээний тайлан,
- МҮБЗШҮ үзүүлэгчдийн нэгдэл холбоо болон бусад байгууллагаас гаргасан тоон мэдээлэл,
- Шүгэл үлээгч нараас гарч буй мэдээлэл,
- Хууль сахиулах байгууллагаас гарсан мэдээлэл,
- Олон улсын мөнгөн хөрөнгийн шилжүүлэг эсвэл хил дамнасан мөнгөн хөрөнгийн талаарх тайлан, улс орны жишээнээс гэх мэт.

Хууль бус, зөвшөөрөлгүй МҮБЗШҮ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагааны эмзэг байдал болдог дараах шалтгаанууд байж болно. Үүнд: хяналт шалгалт болон хүний нөөцийн дутагдалтай байдал, банкны салбарын гаднах бэлэн мөнгө болон түүнтэй адил хөрөнгөөр дамжуулан олон улс хооронд төлбөр тооцоо хийх, санхүүгийн бус үндсэн чиглэлтэй байгууллагууд, банкны системээр дамжуулан гүйлгээ бүрийг бус зөвхөн цэвэр гүйлгээг (зөрүү дүнгээр) хийдэг нь хяналт хийхэд хүндрэл учруулдаг, гэмт хэргийн болон хууль бус орлого, хууль бус хөрөнгийн шилжүүлэг нь худалдааны үйл ажиллагаа мэт харагддаг гэх мэт олон шалтгаан байдаг. Эдгээрээс гадна хамгийн чухал шалтгаан нь өөр өөр улс орны эрх зүйн зохицуулалт нь МҮБЗШҮ-ний гүйлгээг илрүүлэхэд хууль сахиулах байгууллагад хүндрэл учруулж байдаг.

Олон улсад МҮБЗШҮ-ийг ашиглан мөнгө угаах эмзэг байдал нь өндөр гэж үздэг. Энэхүү таамаглалыг шалгах аар нийт 28 орноос санал асуулга авахад 86 хувь нь тийм гэж хариулсан байна. Үлдсэн 4 улс орон нь үгүй буюу МҮБЗШҮ-ийг ашиглан мөнгө угаах эмзэг байдал нь өндөр биш гэж хариулсан байна. Учир нь эдгээр улс орнуудад МҮБЗШҮ-ийг ашиглан мөнгө угаах нь түгээмэл биш бөгөөд тэдгээр улс оронд банкаар дамжуулан энэ төрлийн үйлчилгээг авах нь үр ашигтай байдаг гэсэн байна. ¹⁴


¹⁴ Хавала болон бусад ижил төрлийн үйлчилгээ үзүүлэгч нарын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхэд үзүүлэх үүрэг. The role of Hawala and other similar service providers in money laundering and terrorist financing. [Role-of-hawala-and-similar-in-ml-tf.pdf](#)coredownload.pdf

Зураг 5. МҮБЗШҮ-ийг ашиглан мөнгө угаах эмзэг байдал



Харин МҮБЗШҮ-г ашиглан терроризмыг санхүүжүүлэх эрсдэл өндөр үү? гэсэн асуултад нийт 26 улс орон оролцсоноос 21 улс орон буюу 81 хувь нь тийм гэж хариулсан байна. Зарим улс орон нь МҮБЗШҮ-г ашиглан терроризмыг санхүүжүүлэх эрсдэл өндөр боловч терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой маш цөөн кейс гарсан бөгөөд дотоодын кейс бүртгэгдээгүй хэмээн хариулсан байна.

Зураг 6. МҮБЗШҮ-ийг ашиглан терроризмыг санхүүжүүлэх эрсдэл




МҮБЗШҮ үзүүлэгчдийг ашиглан хууль бус хөрөнгийг дамжуулах үйл ажиллагаа: Hawalas and other similar service providers (HOSSP) буюу Хавала болон бусад ижил төрлийн үйлчилгээнүүд орно. МҮБЗШҮ-г санал болгож буй банк бус санхүүгийн байгууллагууд нь банкны системээр болон банкны системээс гадуур бэлэн мөнгө шилжүүлэх болон зөрүү төлбөр тооцоог шилжүүлэх замаар хийж болно. Хууль бус, зөвшөөрөлгүйгээр Хавала болон ижил төрлийн үйлчилгээг явуулж байгаа бол ихэвчлэн байршуулах үе шат буюу эхний үе шатанд 4 төрлийн хувь хүмүүс оролцдог байна. Үүнд:

1. **Зохион байгуулагч** – Controller гэдэг нь энэхүү системийн амжилттай байх гол түлхүүр юм. Гэмт хэргийн харилцагч нь мөнгийг хэнд, хаана хүлээлгэн өгөх талаарх мэдээллийг хянагчид өгдөг. Хянагч нь мөнгө угаагч гуравдагч этгээдийн үүргийг гүйцэтгэж, олон улс дахь гэмт хэргийн бүлэглэлд үйлчилдэг. Мөн хянагч нарын албанд цуглуулсан, хяналтад байгаа, тараасан мөнгөний бүртгэл хөтлөх хэрэгтэй байдаг. Хянагч нь тухайн мөнгийг цуглуулсан цагаас эхлэн зааврын дагуу амжилттай хүрэх газартаа очих хүртэлх хугацаанд нь хариуцдаг. Хянагч нь тухайн мөнгө нь амжилттай зорьсон газарт хүргэгдээгүй тохиолдолд хариуцлага хүлээдэг байх магадлалтай.

2. **Цуглуулагч** - *Collector* нь Хянагч болон МҮБЗШҮ үзүүлэгчдийн хооронд дамжуулагч болон цуглуулсан мөнгийг зөөвөрлөх үйл ажиллагааг хариуцдаг. Цуглуулагч нь Хянагчаас голдуу гар утас, мессежээр дамжуулан зааварчилгаа авдаг. Ихэвчлэн урьдчилсан төлбөрт дугаар ашиглан хянагчтай холбогдон халхавч уулзалтаар бэлэн мөнгөө цуглуулдаг. Цуглуулсан мөнгийг хүлээн авч тоолон ямар нэгэн асуудал гараагүй тохиолдолд бэлэн мөнгийг хадгалж байгаад хянагчийн заавраар тараадаг.
3. **Зохицуулагч** - *Co-ordinator* нь нэг буюу хэд хэдэн хянагчийн мөнгө угаах үйл ажиллагааны хэсгийг удирддаг этгээдийг хэлнэ.
4. **Дамжуулагч** - *Transmitter* - Энэ үе шат нь МҮБЗШҮ үзүүлэгчдээр дамжин гуравдагч этгээд болон хүлээн авагчид шилжсэн байна. Мөн бэлэн мөнгө нь зохион байгуулалттай бэлэн мөнгө зөөвөрлөгч- Cash courier нараар дамжин өөр гадаад улс оронд шилжин тухайн орны мөнгөн дэвсгэртээр хувирсан байдаг. Энэ нь олон төрлийн МҮБЗШҮ үзүүлэгчдээр дамжин хийгдсэн гүйлгээнүүд байдаг.

Зураг 7. МҮБЗШҮ үзүүлэгчийг ашиглан мөнгө угаахад оролцдог гол оролцогчид



Мэдээлэх үүрэгтэй этгээд нь эдгээр төрлийн оролцогчид болон тэдний үйл ажиллагааг мэдсэнээр хууль бус, зөвшөөрөлгүй МҮБЗШҮ үзүүлэгчийн явуулж буй үйл ажиллагааг таних, типологийг таних, шинж тэмдгээ олж харах, тэдгээрийг илрүүлэхэд үр дүнтэй байх болно. Шинж тэмдгийг таньж, сэжигтэй гүйлгээг илрүүлэхээс эхлээд МҮБЗШҮ үзүүлэгчийг ашиглан мөнгө угаах гэмт хэргийн талаарх хандлагыг таньж мэдэх нь тасралтгүй үйл явц юм.

VI. ОЛОН УЛСЫН ТҮГЭЭМЭЛ ТИПОЛОГИУД

ТИПОЛОГИ 1 – Нэхэмжлэхийн залилан

Өндөр дүнтэй шилжүүлгийг хууль ёсны болгож харагдуулахын тулд хуурамч бараа, ажил үйлчилгээний нэхэмжлэх ашиглан шилжүүлэг хийх. Үүнд илүү нэхэмжлэх, дутуу нэхэмжлэх зэрэг аргууд нь мөн адил тооцогдоно.

ТИПОЛОГИ 2 – Худалдаанд суурилсан мөнгө угаах

Хил дамнасан төлбөрийн шилжүүлэг хийхдээ худалдааны шилжүүлэг ашиглан хийх. Ямар нэгэн худалдааны гэрээ, хэлцлээр халхавч хийж шилжүүлэг хийх. Энэ хэлбэрийн мөнгө угаах арга нь ихэвчлэн нэхэмжлэхийн залилантай хосолсон байдаг.

ТИПОЛОГИ 3 – “Cuckoo” жижиглэн хуваах

Эх үүсвэрийг нь нуун далдлах зорилгоор гол этгээдийн өмнөөс олон хувь хүмүүсийг ашиглан гүйлгээ хийх, гүйлгээг хүлээн авах. Энэ арга нь Их Британи, Европын улсуудад түлхүү ашиглагддаг.

ТИПОЛОГИ 4 – Банкны дансны мэдээллийг нууцлах

Банкны хууль ёсны харилцагч өөрийн дансаа санамсаргүйгээр хууль бус үйл ажиллагаанд ашиглуулах.

ТИПОЛОГИ 5 – Дансны бүртгэл хөтлөх

Хоёр тайлан хөтлөх. Хууль ёсны үйл ажиллагааг бүртгэн эрх бүхий байгууллагад тайлагнахын зэрэгцээ

хууль бус үйл ажиллагааг бүртгэдэг давхар тайлан хөтөлдөг.

ТИПОЛОГИ 6 - Хууль ёсны бизнесээр халхавч хийх

Хууль ёсны зөвшөөрөлтэй МҮБЗШҮ үзүүлэгчийн нэрээр гэмт хэргээс олсон орлогыг шилжүүлэх.

ТИПОЛОГИ 7 – Терроризмыг санхүүжүүлэх

Хууль бус, зөвшөөрөлгүй МҮБЗШҮ үзүүлэгч нь зөвхөн хууль бус үйл ажиллагаа явуулан ашиг олохоос гадна терроризмыг санхүүжүүлэх зорилготой байж болзошгүй.

ТИПОЛОГИ 8 – Ажилтнуудынхаа хувийн данс ашиглах

Халхавч МҮБЗШҮ үзүүлэгч нь өөрийн гэсэн үйл ажиллагаа явуулах байргүй байж болно. Мөн ажилтнууд нь хувийн дансаараа их хэмжээний гүйлгээ хийдэг.

ТИПОЛОГИ 9 – НӨАТ-ын ялгаатай тогтолцоог ашиглах/ Multi-Trader Intercommunity Fraud (MTIC)

MTIC нь Европын холбооны улс орнуудын НӨАТ-ын ялгаатай байдлыг ашиглах зорилготой зохион байгуулалттай үйл ажиллагааг хэлдэг. Энэ үйл ажиллагааны үед МҮБЗШҮ-г түгээмэл ашиглан олон улс хооронд шилжүүлэг хийдэг.

ТИПОЛОГИ 10 – Хар тамхины орлогоо дамжуулах

Гэмт хэрэгтнүүд МҮБЗШҮ-г хар тамхины орлогоо дамжуулахад түгээмэл ашиглан дотооддоо болон олон улс хооронд шилжүүлэг хийдэг.

*ТИПОЛОГИ 11 - Олон жижиг
хэсгүүдэд хуваах/structuring
(Smurfing)*

Гуйвуулагч нь их хэмжээний мөнгийг жижиг хэсгүүдэд хуваан, гуйвуулах. Энэ нь тайлагнах босго дүнгээс бага учраас эрх бүхий байгууллагуудад таньж илрүүлэхэд нь хүндрэлтэй байдаг.

*ТИПОЛОГИ 12 – Эргэлдүүлэх/
Cycling*

Эх үүсвэрийг нь нуун далдлах зорилгоор тодорхой давтамжтайгаар олон дансанд орлого болон зарлагын гүйлгээг гуйвуулгаар шилжүүлэх.

*ТИПОЛОГИ 13– Хул
дамнуулах/ Cross-Border Schemes*

Олон Улсын гуйвуулгыг үйлчилгээг ашиглан мөнгө угаахтай тэмцэх тогтолцоо сул хөгжсөн өөр улс руу шилжүүлэх. Эдгээр сул тогтолцоотой эдийн засаг руу бохир мөнгөө оруулахад хялбар байдаг.

*ТИПОЛОГИ 14 - Хуурамч бичиг
баримт ашиглаг*

Хуурамч бичиг баримт болон хулгайлсан бичиг баримтыг ашиглан мөнгөн гуйвуулга хийх. Энэ нь тухайн гүйлгээний жинхэнэ эзнийг нуух зорилготой.

*ТИПОЛОГИ 15 – Гуравдагч
этгээдэд дансаа ашиглуулах*

Гэмт хэрэгтнүүд гуравдагч этгээдийн данс нээж, шилжүүлэг хийх. Эдгээр халхавч данс нь мөнгөний эх үүсвэрийг нуухад зориулагдсан байдаг.

*ТИПОЛОГИ 16 – Франчайзын
гэрээтэй олон улсын компанийг
ашиглах*

Франчайзын гэрээгээр олон улсад үйл ажиллагаа явуулдаг, танигдсан олон улсын корпорациуд болон үндэсний компаниар дамжуулан хууль бус мөнгийг шилжүүлэх.

*ТИПОЛОГИ 17 – Өөр хууль ёсны
бизнесээр халхавчлах /Covert ARS
(Alternative remittance service)
Operations within Another Business*

МҮБЗШҮ үзүүлэгч нь өөр ямар нэгэн бизнесийн дотор үйл ажиллагаа явуулдаг. Жишээ нь өөр улсаас бараа бүтээгдэхүүн оруулж ирдэг бизнесийн төрлүүд.

*ТИПОЛОГИ 18 – Тодорхой
байршилгүй байх*

МҮБЗШҮ үзүүлэгч нь тодорхой бус байршилд үйл ажиллагаа явуулдаг.

*ТИПОЛОГИ 19 – Хамаарал бүхий хэд
хэдэн хувь хүмүүсийн хооронд
давтамжтай хийгдэх*

Хоорондоо холбоо хамаарал бүхий хэд хэдэн хувь хүмүүсийн хооронд давтамжтайгаар хийгдэж буй шилжүүлгийн гүйлгээнүүд.

*ТИПОЛОГИ 20 – Эдийн засгийн үйл
ажиллагаа, улс орны орны
онцлогтой нийцэхгүй гүйлгээ хийх*

Эдийн засгийн үйл ажиллагаа болон улс орнуудын хооронд, эсвэл хувь хүмүүс болон шилжүүлгийн хоорондох үл нийцэл.



Эдгээр типологиуд нь зохицуулагч эрх бүхий байгууллага болон мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэгчид аль алинд нь тодорхой асуудлуудыг үүсгэж байдаг. Эдгээр типологиудыг таньж мэддэг байх нь мөнгөн гуйвуулгын үйлчилгээг ашиглан мөнгө угаах үйлдлийн эсрэг авч буй хамгийн эхний арга хэмжээ юм. Тухайн типологийг таньж мэддэг байхын тулд шинж тэмдэг бүрийг ажиглах шаардлагатай.

VII. КЕЙСҮҮД

КЕЙС 1- Олон жижиг хэсэгт хуваах


Харилцагч: Хувь хүн/ хуулийн этгээд

Арга: Мөнгөн гуйвуулга

Шинж тэмдэг: Хэд хэлэн валют ашиглах, жижиг хэсгүүдэд хуваасан гүйлгээнүүд, олон хувь хүмүүс оролцох, богино хугацаанд маш олон тооны гүйлгээ хийгдэх.

Болгар улсын хэд хэдэн хувь хүн болон хуулийн этгээд нь өөр өөр гадаад улс орон, хувь хүмүүсээс (ихэвчлэн гадаад улс орнууд) богино хугацаанд өндөр дүнтэй шилжүүлэг хүлээн авсан. Тэгээд тэд үйл ажилагаагаа түр зогсоож, хэсэг хугацааны дараа дахин шилжүүлэг хийж эхэлсэн.

Энэхүү схемд их хэмжээний мөнгийг жижиг хэсгүүдэд хуваан өөр өөр улс орнуудын олон хувь хүмүүст илгээж, буцаан цуглуулсан. Хүлээн авсан болон илгээсэн мөнгөн гуйвуулгын нийт дүн ойролцоо бөгөөд шилжүүлэгчид нь хүлээн авагчдыг таньдаг гэдгээ мэдэгдсэн.



Уг шилжүүлэг нь хэд хэдэн валютаар хийгдсэн бөгөөд нэг валютаас нөгөө валют руу хөрвөх нь ямар нэгэн үндэслэлтэй тайлбаргүйгээр хийгдэж байсан. Мөрдөн шалгалтын явцад уг схемд оролцсон олон гадаад хувь хүмүүс нь гэмт хэрэг үйлдэж байсан, хар тамхины наймаа, биеэ үнэлэх гэмт хэргээр ял шийтгүүлж байсан болохыг тогтоосон байна.

Эх үүсвэр: Болгар улс

КЕЙС 2- Өндөр эрсдэлтэй улс орнууд руу шилжүүлэг хийх

Харилцагч: Хувь хүн

Арга: Мөнгөн гуйвуулга

Шинж тэмдэг: жижиг хэсгүүдэд хуваасан гүйлгээ, хэд хэдэн эцсийн өмчлөгчид, өндөр эрсдэлтэй улс орнуудад шилжүүлэг хийх, хуурамч хүн (straw man) ашиглах, гэмт хэрэгт оролцож байсан этгээд оролцох, илгээгчийн эдийн засгийн төлөвт нийцэхгүй гүйлгээ.

Санхүүгийн мэдээллийн алба нь А улсаас Өмнөд Африкийн хэд хэдэн улс руу хоорондоо холбоогүй хэд хэдэн хуулийн этгээдийн алдартай мөнгө гуйвуулагчаар дамжуулан хийсэн шилжүүлэгтэй холбоотой сэжигтэй гүйлгээний тайлангуудыг Шуудангийн банкнаас хүлээн авсан.



Дүн шинжилгээгээр дээрх гадаад улс руу хийгдсэн шилжүүлгүүд нь жижиг дүнгээр хийгдсэн байгааг гаргаж ирсэн. Тэдгээр шилжүүлэг нь Шуудангийн банкны А улсын нэг мужид байрлах өөр өөр салбараас Өмнөд Африкийн хар тамхины үйлдвэрлэлтэй холбоотойгоор өндөр эрсдэлтэй гэж үздэг хэд хэдэн улс оронд байрлах олон төрлийн хүлээн авагч руу шилжүүлсэн байна. Эдгээр хуулийн этгээдийн хийсэн мөнгөн шилжүүлгүүдэд гэмт хэрэгт холбогдож байгаагүй, орлого болон хөрөнгө багатай залуу хүмүүс оролцсон байсан. Тиймээс Сэжигтэй гүйлгээний тайлангийн үндэслэл нь “хуурамч хүн” ашигласан гэсэн байна.

Мөн хар тамхи зөөвөрлөх үйл ажиллагаа явуулдаг гэмт хэргийн томоохон бүлэглэлийн нэг гишүүн оролцсон байсан нь мэдэгдсэн. Өмнөд Африкийн СМА-тай хамтран ажилласны үр дүнд мөнгөн шилжүүлгийн хүлээн авагчдын нэг нь хар тамхи зөөвөрлөх гэмт хэргээр ял шийтгүүлж, ялаа эдэлж байгаа болохыг олж мэдсэн.

Эх үүсвэр: Израйл

КЕЙС 4- Өндөр эрсдэлтэй улс оронд, жижиг дүнд хуваасан шилжүүлгүүд

Харилцагч: Хувь хүн


Арга: Мөнгөн гуйвуулга

Шинж тэмдэг: Ажил эрхлэлт, бизнестэй нь үл нийцэх гүйлгээ, харилцаа хамааралгүй хил дамнасан, тогтмол шилжүүлэг.

А хүний санхүүгийн үйл ажиллагаа нь ажил мэргэжилтэй нь нийцээгүй гэсэн үндэслэлтэй СГТ-нг хүлээн авсан. А хүн Р хотын оршин суугч бөгөөд жижиг хувцасны дэлгүүр ажиллуулдаг байсан ч алслагдсан бүс нутгууд болон Q хотоос, холбоо хамааралгүй хуулийн этгээдээс мөнгө хүлээн авдаг байжээ. Сүүлийн гурван жилийн хугацаанд А хүний гурван өөр банкны долоон дансны эргэц нь 474 сая PKR (ойролцоогоор 1.65 сая ам.доллар) байсан.

Дүн шинжилгээгээр дээрх мөнгөний орж ирж буй урсгал нь ихэвчлэн Q хотод байдаг В хүнээс мөнгө авч байсан нь тогтоогдсон. В этгээдийг СМА-ны дотоод мэдээллийн санд хайлт хийхэд СМА нь уг этгээдийг хууль бус хавала/хиндү үйл ажиллагаа явуулсан байж болзошгүй, мөн дотоодын хориотой байгууллагатай холбоотой байж болзошгүй гэж үзэн Терроризмтой тэмцэх газар (CTD) болон Холбооны мөрдөн шалгах байгууллагад шилжүүлсэн болохыг тогтоосон. Дүн шинжилгээний явцад А, В хоёрыг Терроризмтой тэмцэх газар (CTD)-д шалгаж байгаа нь тогтоогдсон. А хүнээс гадагшаа чиглэсэн хөрөнгийн урсгалд дүн шинжилгээ хийхэд Q улсын харьяаллын 450 орчим харилцагчид руу бага хэмжээгээр тогтмол мөнгө илгээдэг нь тогтоогдсон. Цаашлаад, эдгээр харилцагчдын гүйлгээнд хийсэн дүн шинжилгээ нь мөнгө хүлээн авч байсан олон хүмүүс хориглогдсон байгууллагатай холбоотой байж болзошгүй хэмээн Холбооны мөрдөн шалгах байгууллагад шалгагдаж байсан нь тогтоогджээ.

Кейс тойм:



Эх үүсвэр: Пакистан¹⁵

¹⁵ [file:///E:/Research/paper/Typology%20report money%20transfer/2023%20APG%20Typologies%20Report](file:///E:/Research/paper/Typology%20report%20money%20transfer/2023%20APG%20Typologies%20Report)

КЕЙС 5- Терроризм

Харилцагч: Хувь хүн

Арга: Мөнгөн гуйвуулга

Шинж тэмдэг: гэмт хэрэгтнүүдийн бусад улс орон руу хийсэн хэвийн бус мөнгөн шилжүүлэг

Х этгээд нь гар хийцийн тэсрэх бөмбөг хийхэд зориулан бордоо худалдан авах, тээвэрлэх, нууцлахтай холбоотой худалдан авалттай холбоотой CREVICE үйл ажиллагааны хариуцагч байсан. Х этгээд нь 2017 онд хүний амь нас хохироосон, тэсэрч дэлбэрэх бодис ашиглан хүний амь насанд аюул учруулах, хүнд гэмтэл, эд хөрөнгөд хохирол учруулахуйц шинж чанартай дэлбэрэлт зохион байгуулсан хэрэгт гэмт буруутайд тооцжээ. Түүнд 40 жилийн ял оноожээ.

Х этгээд нь 2007/11/03-2012/11/03 хооронд Barclays Bank PLC ны данснаасаа 2540 фунт стерлинг бэлнээр авсан байна. 2012/11/03-нд Х этгээд нь Пакистан улсын Хариан хотын Ү руу WU-Western Union ашиглан 2471 фунт шилжүүлж, 233 326,5 руфе болгож хөрвүүлсэн байна. Ү этгээд нь 2004 онд баривчлагдаж байсан АНУ-ын иргэн байна. Тэрээр террорист гэмт хэрэг үйлдсэн гэдгээ хүлээн зөвшөөрч 70 жилийн хорих ялаар шийтгүүлсэн байна.

Эх үүсвэр: АНУ

КЕЙС 6- Терроризм

Харилцагч: Хувь хүн/хуулийн этгээд

Арга: Мөнгөн гуйвуулга

Шинж тэмдэг: гэмт хэрэгтнүүдийн бусад улс орон руу хийсэн хэвийн бус мөнгөн шилжүүлэг

2008 оны 11 дүгээр сард АНУ-д оршин суудаг Пакистан улсын иргэн Х нь терроризмыг санхүүжүүлэхийг нуун дарагдуулсан, мөнгө угаах үйл ажиллагааг зохион байгуулсан тул 110 сараар ял шийтгүүлээд 3 жилийн ялыг эдлээд суллагдсан байна. Мөн түүний 2 208 000 ам.долларын хөрөнгийг хураахаар шийдвэр гарсан. Х этгээд нь Вашингтон Д.С-д үйл ажиллагаа явуулдаг А компанийг удирддаг. А этгээд болон Х компани болон 5 шүүгдэгч компаниас авсан 2 208 сая ам.долларыг угаахын тулд хуйвалдаан зохион байгуулсан гэж буруутгагдсан байна. Тухайн мөнгө нь хар тамхины наймаа, терроризмыг санхүүжүүлэх болон хууль бус тамхины наймаанаас олсон орлого байсан.

Эх үүсвэр: АНУ

КЕЙС 7- Албан бус мөнгөн гуйвуулга

Харилцагч: Хувь хүн

Арга: Хууль бус мөнгөн гуйвуулга

1. Бельги улсад оршин суудаг Зүүн Африкийн иргэн Х нь Хавала үйл ажиллагаа явуулдаг гэж мэдэгджээ. Түүний дансанд маш их хэмжээгээр бэлнээр болон жижиг дүнгээр зарлагын гүйлгээ хийгдсэн байна. Хэдэн сарын дотор тэдгээр бүх мөнгө нь зүүн Африкийн А компанид шилжсэн. Удалгүй баруун Европ дахь Б компани руу шилжүүлсэн. Дээрх А олон Б компаниуд нь дэлхийн өнцөг булан бүрд мөнгөн гуйвуулгын үйл ажиллагаа явуулж байсан. Х этгээд нь зүүн Африк руу мөнгө шилжүүлэх хүсэлтэй нутаг нэгтнүүддээ зориулан Хавала үйл ажиллагаа явуулдаг байсан гэж мэдэгджээ. Гэвч тэрээр Бельги улсын компаниудад албан ёсоор ажил эрхэлдэггүй байсан бөгөөд арилжааны болон мөнгөн гуйвуулгын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй байсан. Мөн ямар нэг банкны хянан шалгагч гэх мэт эрх байгаагүй. Цагдаагийн байгууллагаас түүнийг террорист бүлгийн гишүүн байсан гэж тогтоосон байна. Тиймээс энэ тохиолдолд мөнгөн гуйвуулгын үйлчилгээг терроризмыг санхүүжүүлэхэд ашигласан байж болзошгүй хэмээн шалгаж байна.

2. 2008 оны 9 сард Канад улсад оршин суудаг Пакистан улсын иргэн Х мөнгө угаах үйл ажиллагаа зохион байгуулсан гэдгээ хүлээн зөвшөөрсөн. Үүний дагуу Х нь Канад улсын Монтреалд мөнгөн шилжүүлгийн үйл ажиллагаа эрхэлж дотоодын болон гадаадын ул орнуудад мөнгө шилжүүлэхийн тулд Хавала буюу албан бус мөнгөн гуйвуулгын үйлчилгээгээр дамжуулан мөнгө шилжүүлдэг байсан.

Хамтран ажиллаж байсан гэрч нь хууль сахиулах байгууллагын зааврын дагуу Х болон түүний хамтрагчдыг олон улсын хэмжээнд хар тамхины хууль бус наймаа, хуурамч тамхины хууль бус худалдаанд оролцдог хэмээсэн байна. 2004 оны 1 дүгээр сараас 2005 оны 11 дүгээр сар хүртэл Х этгээдийн хамтран шүүгдэгч Ү этгээд нь АНУ-аас 828 000 ам.долларын 10 удаагийн шилжүүлэг хийхэд тусалсан байна. Хамтран ажиллаж байсан гэрч нь хар тамхины наймаанаас олсон орлого бөгөөд Х этгээд уг мөнгийг угаахын тул дээрх бүх үйл ажиллагааг хийсэн гэж мэдүүлсэн.

Эх үүсвэр: АНУ

КЕЙС 8- Хуурамч бичиг баримт ашиглах

Харилцагч: Хувь хүн


Арга: Мөнгөн гуйвуулга

Шинж тэмдэг: Жижиг хэсгүүдэд хуваасан гүйлгээ, ижил хүлээн авагчид, богино хугацаанд өндөр дүнтэй гүйлгээ хийх,

Б болон В хувь хүмүүс тогтмол бэлэн мөнгөөр орлого хийж мөнгөн гуйвуулгын үйлчилгээг ашиглан өмнөд Африкийн иргэн рүү (хүлээн авагч нэг хүн байдаг) шилжүүлдэг.

Хэдэн сарын хугацаанд дээрх шилжиж ирсэн мөнгө нь хэдэн мянган евро болсон. Эдгээр гүйлгээнд ямар нэгэн эдийн засгийн үндэслэл байхгүй бөгөөд дээрх хувь хүмүүсийн хэн нь ч хаяг дээрээ оршин суудаггүй.

Мөнгө гуйвуулгын маягтаас харахад ихэнх гүйлгээ нь А-ийн хийсэн гүйлгээ бөгөөд үүний дараа В-ийн хийсэн гүйлгээнүүд ч бас ижил хүлээн авагчтай байсан.



Дээрх хоёр хүний бичиг баримтыг харьцуулан харахад нэг хүн болох нь тогтоогдсон. Цагдаагийн газрын тогтоосноор А-ийн мэдээлэл нь хүний наймаа, биеэ үнэлэхтэй холбоотой хэргийн мөрдөн шалгалтаар илэрсэн байна.

VIII. ШИНЖ ТЭМДЭГ

Мөнгөн гуйвуулгын үйлчилгээг ашиглан мөнгө угаах гэмт хэрэг үйлдэх явцад хийгдэж буй гүйлгээний шинж тэмдгийг мэддэг байх нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, сэрэмжлүүлэхэд чухал үр нөлөөтэй. Энэхүү шинж тэмдгийг үр дүнтэй хяналт шалгалт, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны үндсэн дээр тодорхойлдог бөгөөд ингэснээр мэдээлэх үүрэгтэй этгээдийн мэдээлдэг сэжигтэй гүйлгээний сэжиглэх үндэслэл нь илүү тодорхой болдог. Шинж тэмдгүүд нь харилцагчийн ажил эрхлэлт, хийж буй гүйлгээ, харилцагчийн зан төлөв гэх мэт маш олон хүчин зүйлтэй холбоотой.

8.1 Ерөнхий шинж тэмдгүүд

- *Цуглуулагч дансыг байнга ашиглах.* Хэрэв харилцагчийн дансанд олон удаагийн бага дүнтэй мөнгө (ихэвчлэн өөрсдийнхөө нэр нь нэмэлт хэсэг дээр) орж ирэх, эсвэл өмнө нь тогтмол хугацаанд өндөр дүнтэй бэлэн мөнгө байршуулж тухайн данснаас нэгтгэсэн дүнгээр гадаад улс руу шилжүүлэг хийдэг бол хамтын данснууд гэж үзэж болох юм.
- *Дубай гэх мэт олон улсын худалдааны төв болсон газар руу тогтмол хугацаанд мөнгө шилжүүлэх.* Дубай бол мөнгөн гуйвуулга буюу мөнгө, үнэ бүхий зүйл шилжүүлэх олон улсын томоохон төв юм. Олон худалдааны компаниуд/гэмт бүлэглэлүүд хууль бус мөнгөө Дубайгаар дамжуулан Хавала сувгаар өөр газар руу шилжүүлдэг. Ихэнх хайбрид хавала гүйлгээг Дубай зэрэг олон улсын томоохон төвөөр дамжуулдаг.
- *Дансыг түр хадгалах газар болгон ашигладаг* бөгөөд тухайн дансны мөнгийг дансанд оруулангуутаа буцаан гаргах замаар гадаад улс руу шилжүүлдэг.
- *Хууль сахиулах байгууллага илрүүлэхээс зайлсхийх зорилгоор гуравдагч этгээдийн дансыг ашиглах.* Ихэнхдээ ийм гуравдагч этгээдийн данснууд хүлээн авагч (hawaladar) эсвэл илгээгчтэй ямар ч бизнесийн холбоогүй байдаг.
- *Илгээгч улс дахь данснаас олон улсын банк руу тогтмол мөнгөн шилжүүлэг хийх үйл ажиллагаа.*
- *Худалдааны бизнес эрхлэгчид нь ямар нэгэн бизнесийн холбоогүй гадаад улс руу тогтмол мөнгөн гуйвуулга хийх.*
- *Мөнгө гуйвуулагч буюу худалдааны бизнес эрхлэгчдийн хийж байгаа гүйлгээ нь Сэжигтэй гүйлгээний тайлан (STR) эсвэл Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан (CTR) тайлагнах босго дүнгээс доош дүнтэй гүйлгээг тогтмол хийх.*
- *Бизнесийн данснууд нь өндөр дүнтэй мөнгө хүлээн авах, зарцуулахад ашиглагддаг боловч цалингийн төлбөр, нэхэмжлэх гэх мэт бизнестэй холбоотой ердийн үйл ажиллагаанууд ашиглагддаггүй байх.*
- *Гуравдагч этгээдийн чек, бэлэн мөнгөн шилжүүлгийг бизнесийн болон хувийн дансанд тогтмол байршуулах.*

- Бизнесийн үйл ажиллагаатай нь нийцээгүй олон улсын мөнгөн гуйвуулгын гүйлгээг тогтмол хийх.
- Олон хувь хүнээс нэг ижил банкны дансанд тогтмол мөнгө байршуулж, дараа нь олон улсын мөнгөн гуйвуулга болон/эсвэл АТМ-ээр дамжуулан мөнгө авах.
- Мөнгөн шилжүүлэг хийдэг дансны гүйлгээ нь бага дүнтэй олон улсын шилжүүлгээс өндөр дүнтэй шилжүүлэг хийдэг болж, гүйлгээний хэв маяг нь гэнэт өөрчлөлт гарах.
- *Өндөр дүнтэй бэлэн мөнгөний орлого тогтмол хийх,*
- *Тогтмол олон тооны гадаад шилжүүлгийг мэдэгдэж буй мөнгөн гуйвуулгын коридор улс орон эсвэл мэдэгдэж буй хүлээн авах улс орны бус өөр гуравдагч этгээдийн дансанд хийх,*
- *Цагаач иргэдийн данс эзэмшигчдийн дундаж орлогоос давсан бэлэн мөнгөний хэмжээ ба олон улсын мөнгөн гуйвуулга, мөн цагаач иргэдийн мөнгөн гуйвуулгын эрэлтийн илүүдэл,*
- Бизнесийн хэмжээ болон бэлэн мөнгөний хэмжээг тайлбарлаж чадахгүй байх, хуулийн этгээдийн хэвийн эх үүсвэртэй нийцэхгүй байгаа олон улсын мөнгөн гуйвуулга,

8.2 Гүйлгээтэй холбоотой шинж тэмдгүүд

- Тухайн гүйлгээ нь шаардлагагүйгээр нарийн төвөгтэй байдлыг агуулсан байх,
- Халхавч компани болон хувь хүн ашиглах,
- Давтамжтай хийгдэж буй гүйлгээнүүд нь харилцагчийг таньж мэдэхээс зайлсхийж босго дүнгээс дөнгөж доогуур байх,
- Харилцагч тайлагнах шалгуураас зайлсхийж 2 буюу түүнээс олон МҮБЗШҮ үзүүлэгчийг нэг өдөрт ашиглах,
- Харилцагч нь ямар нэг бизнесийн зохих харилцаагүйгээр гуравдагч этгээдийн нэрийн өмнөөс гүйлгээг эдгээр талуудтай хийх,
- Нэг ижил харилцагчийн хийсэн давтамжтай гүйлгээний захиалгууд,
- Үндэслэлтэй тайлбаргүйгээр тухайн харилцагчийн гүйлгээний давтамж/мөнгөн дүн нь гэнэт нэмэгдэх,
- Хэвийн бус өндөр дүнтэй (бэлэн) гүйлгээ,
- Ердийн МҮБЗШҮ үзүүлэгч болон харилцагчийн хувьд хэт өндөр дүнтэй гүйлгээ хийх,
- Гүйлгээ нь тодорхой зорилгогүй, эдийн засгийн болон санхүүгийн үндэслэлгүй,
- Шаардлагагүй арга замаар гуравдагч этгээд рүү шилжүүлэх,
- Харилцагч нь МУТСТ хууль тогтоомжид хамаарахгүй дундын зуучлагчийг ашиглах,

- Харилцагч нь тодорхой зорилгогүй өөрөө өөрөөсөө мөнгө шилжүүлж, хүлээн авдаг.
- Харилцагчид тухайн МҮБЗШҮ-г ашиглах тодорхой шалтгаан байхгүй,
- Бэлнээр төлбөр төлөхийн тулд өндөр дүнтэй мөнгийг өөр улс орон руу шилжүүлэх, хүлээн авах,
- Харилцагч нь "татварын диваажин" гэж тооцогддог улс орон эсвэл хамтран ажилладаггүй улс орнуудаас (тогтмол) төлбөр илгээдэг буюу хүлээн авдаг,
- Нэг хуулийн этгээд нь олон хуулийн этгээдэд мөнгө шилжүүлдэг,
- Нэг хуулийн этгээд/иргэний олон хуулийн этгээд/иргэнээс (өөр өөр улс орноос) мөнгө авдаг,
- Нэг хуулийн этгээд/иргэний захиалгаар шилжүүлсэн шилжүүлгийг олон хуулийн этгээд/иргэн (төрөл садны/ бизнесийн ямар ч холбоогүй) хүлээн авсан байдаг,
- Насанд хүрээгүй хүн олон хуулийн этгээд болон/эсвэл өөр өөр газраас мөнгө хүлээн авдаг,
- Харилцагч нь хар тамхины наймаа, терроризмыг санхүүжүүлэх, хууль бусаар хил нэвтрүүлэх зэрэг эрсдэлд өртөж болзошгүй улс орнуудын харьяалалтай этгээд рүү мөнгө илгээх/хүлээн авах,
- Харилцагчид нь баталгаажуулах зорилгоор биечлэн ирдэггүй,
- Гүйлгээний талаарх мэдээлэл нь илт худал эсвэл зөрчилтэй мэдээлэл байдаг,
- Харилцагч нь ердийн шаардагдах мэдээллийг өгөх хүсэлгүй, эсвэл өгсөн мэдээлэл нь хангалтгүй, худал эсвэл мөнгөн гуйвуулга/валют арилжааны зорилгоор баталгаажуулахад хүндрэлтэй байх,
- Хөрөнгийн гарал үүслийн талаарх мэдээлэл байхгүй эсвэл хязгаарлагдмал байх,
- Бизнесийн үйл ажиллагаа болон холбогдох хөрөнгийн талаарх тайлбар нь итгэлтэй бус байх,
- Их хэмжээний мөнгөтэй холбоотой цахим шилжүүлэг нь уг гүйлгээг ойлгомжтой тодорхойлох хэмжээний мэдээллийг агуулаагүй байх,
- 2 талт мөнгөн орлогын дараа яг ижил дүнгээр мөнгөн шилжүүлэг хийгдэх,
- Харилцагчийг дагалдан явагсад нь харилцагчийн хувийн хэрэг дутуу эсвэл гадна хүлээж байх,
- Харилцагчид нь өөрөө бичээгүй бололтой ямар нэг тэмдэглэлээс харж уншиж өгдөг,
- Харилцагч нь бусдаас зааварчилгаа авдаг байж болзошгүй,
- Харилцагчаас дэлгэрэнгүй мэдээллийг асуухад эргэлзсэн байдалтай байдаг,

- Эцсийн хүлээн авагчийн талаарх мэдээллийг авахад хүндрэлтэй байдаг,
- Илгээгч болон хүлээн авагчийн хооронд харилцаа, холбоо байхгүй,
- Үйл ажиллагаа тогтмол бус байх,
- Дагалдах баримт бичиг нь харилцагчийн өгсөн бусад мэдээлэлтэй нийцдэггүй,
- Харилцагч нь гүйлгээ хийх гэж яарах, бусад нэмэлт мэдээллийг дараа нь өгнө гэж амлах,
- Харилцагч нь бизнесийг төлөөлж байгаа боловч бизнесийн туршлагагүй юм шиг санагдах,
- Бэлэн мөнгө гаргах эрх нь үндэслэлгүй юм шиг санагдах,
- Дамжуулах мэдээлэл нь харилцагчаас өөр хүнд илгээгддэг,
- Их хэмжээний бэлэн мөнгө гаргах, гадаад руу шилжүүлэхийн өмнө харилцагчийн дансанд юу байршуулсан талаарх мэдээлэл шаардлагатай байх,
- Харилцагч нь маягтыг урьдчилан бөглөсөн байх,
- Бизнесийн харилцаа үүссэнээс хойш гүйлгээний хэлбэр өөрчлөгдсөн,
- Харилцагчийн ердийн бизнесийн гадаад харилцаатай нийцэхгүй байгаа өндөр эрсдэлтэй улс оронд тайлбаргүйгээр мөнгө шилжүүлэх,
- Үндэслэлтэй тайлбаргүйгээр тухайн харилцагчийн гүйлгээний давтамж/мөнгөн дүн гэнэт нэмэгдэх,
- Гүйлгээ хийхээс өмнөхөн төлбөрийн заавар гэнэт өөрчлөгдөх,
- Харилцагч шалтгаангүйгээр өөрийн оршин суугаа газар, ажлаасаа хол байрлах салбар/агентууд руу удаа дараа очдог,
- Санхүүжилтийг цалингийн төлбөртэй холбоогүй цагт илгээдэг,
- Бэлэн мөнгөний гүйлгээний хувьд цагаачдын мөнгөн гуйвуулгын коридороос гадуур илгээсэн мөнгөн гуйвуулга,
- Төлбөрийг чек, банкны карт гэх мэтчилэнгээр хийх тохиолдолд ер бусын их хэмжээний бэлэн мөнгөний төлбөр хийх,
- Бэлэн мөнгө нь ашигласан, хуучирсан мөнгөн тэмдэгт ба/эсвэл жижиг мөнгөн тэмдэгтүүд (мөнгө нь гэмт хэргээс үүдэлтэй байж болзошгүй шинж тэмдэг) байх,
- Харилцагч нь бэлэн мөнгөний эх үүсвэрийг задруулахаас татгалзсан,
- Харилцагчийн авчирсан мөнгөн дэвсгэрт нь жижиг мөнгөн дэвсгэрттэй, бохир; мөнгөн дэвсгэртийг зөөвөрлөсөн буюу далдалсан, эсхүл хөгц үнэртсэн, хайнга савласан, тунадастай байсныг илтгэх толбо; мөнгийг тоолох үед мөнгөн гуйвуулга болон валют арилжааны үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан гарсан дүн болон харилцагчийн дүнгийн хооронд ихээхэн зөрүү гарсан (дээш эсвэл бага);

8.3 Харилцагчийн мэдээлэлтэй холбоотой шинж тэмдгүүд

- Харилцагчийн оршин суугаа газар нь ажил эрхлэлт гэх мэт бусад хувийн мэдээлэлтэй нийцэхгүй байна,
- Гүйлгээний хэмжээ, давтамж нь харилцагчийн хэвийн үйл ажиллагаатай нийцэхгүй байна,
- Худалдан авсан бараа/валют болон/эсвэл төлбөрийн зохицуулалт нь энэ төрлийн бизнесийн ердийн үйл ажиллагаанд нийцэхгүй байна,
- Харилцагчийн хаяг нь шуудангийн хайрцаг эсвэл “с/о” тэмдэглэгээтэй буюу өөр хэн нэгний хаягийг ашигладаг,
- Харилцагчийн хаяг нь бизнесийн үйлчилгээ үзүүлэгчийн хаяг (оршин суух хаягаар хангах үйлчилгээ),
- Харилцагчийн хаягийн мэдээллийг шалгахад хэцүү, хүндрэлтэй,
- Захидлын шуудангийн хаяг нь харилцагчийн албан ёсны хаягаас өөр байна,
- Тодорхой заасан хаяггүй байх,
- Заасан хаягаар олон тооны хүмүүс бүртгэлтэй, эсвэл маш олон оршин суугч сольж байгаа, эсвэл оршин суугаа, оршин суугаа газрын бодит хаяг биш гэдгийг илтгэх бусад мэдээлэл байгаа,
- Харилцагчийн оршин суугаа газрын хаяг нь харилцагчийн санхүүгийн зохицуулалттай тохирохгүй байна,
- Харилцагч нь хаягаа байнга сольдог,
- Харилцагч нь өөрийн нэрээр явуулдаг бизнесийн гүйлгээтэй нь нэр, зорилго нь үл нийцэх,
- Харилцагч нэмэлт бичиг баримтыг нэн даруй гаргаж өгөх боломжгүй байх,
- Иргэний үнэмлэхийг ашиглах боломжгүй байх,
- Иргэний үнэмлэх нь бохирдсон тул шаардлагатай мэдээллийг уншихад хүндрэлтэй байх,
- Харилцагч нь гэмт хэрэгт холбогдож байсан түүхтэй байх,
- Харилцагч нь гэмт хэрэгт холбогдож байсан хүнтэй ойр байдаг,
- Харилцагчийн амьдралын хэв маяг гэнэт өөрчлөгдсөн,
- Харилцагч өөрийн орлогын байдалд тохирохгүй маш үнэтэй машин унадаг,
- Харилцагч өөрийн орлогын байдалд тохирохгүй үнэтэй хөрөнгө (жишээ нь, үл хөдлөх хөрөнгө, машин) хөлслөх буюу түрээслэх,

8.4 Харилцагчийн зан байдалтай холбоотой шинж тэмдгүүд

- Харилцагч өөрийн хувийн мэдээлэл, лавлагааны дэлгэрэнгүй мэдээллийг өгөхийг хүсэхгүй байх,
- Их хэмжээний бэлэн мөнгө гаргаж авах, гадаад руу шилжүүлэхийн өмнө харилцагчийн дансанд ямар зориулалттай мөнгө байршуулсан талаарх шаардлагатай мэдээлэл дутмаг,
- Хуурамч иргэний үнэмлэх ашиглан мөнгө илгээх,
- Харилцагч үнэмлэхээ харуулах ёстой гэдгээ мэдсэнийхээ дараа гүйлгээгээ өөрчлөх,
- Харилцагч шилжүүлэгтэй холбоотой гарах зардлыг сонирхдоггүй,
- Харилцагч гүйлгээ хийх хамгийн энгийн аргыг сонгодоггүй,
- Харилцагч нь бизнесийн харилцаа тогтоосон газартай ямар ч холбоогүй байх,
- Харилцагч нь харилцагчийн харилцаа холбоо эсвэл гүйлгээний шалтгааны талаар давтагдсан, нэлээд дэлгэрэнгүй тайлбарыг өгдөг,
- Захиалагч тодорхойлсон хаягаар ирсэн захидалд хариу өгөхгүй,
- Харилцагч нь шинээр байгуулагдсан олон компанитай,
- Харилцагч нь түүнтэй адилтгах баталгааг барьцаалан зээл авах гэрээ байгуулна,
- Харилцагчийн бизнес байрладаггүй гадаад улсад шилжүүлэг хийх байдаг,
- Харилцагч нь гуравдагч этгээдээс авсан зээлээр үнэтэй хөрөнгө авсан гэх тайлбарлах,
- Харилцагч нь өөрийн оршин суугаа улсаас өөр улсын төлбөрийн карт ашигладаг,

8.5 МҮБЗШҮ үзүүлэгч/МҮЭ/-д зориулсан шинж тэмдгүүд

- Эдийн засгийн илт шалтгаангүйгээр хөрөнгө шилжих,
- Төлбөрийг ихэвчлэн чек, банкны карт гэх мэт хэрэгслийг ашиглан их хэмжээний бэлэн мөнгөний төлбөр хийх,
- Гэрээнд суурилсан гүйлгээгүйгээр (хэлцэл) мөнгө шилжүүлэх,
- Харилцагчийн бизнесийн гадаад харилцаатай нийцэхээргүй үндэслэл, тайлбартайгаар өндөр эрсдэлтэй улс орон руу мөнгө шилжүүлэх,
- Богино хугацаанд өөр өөр дүнтэйгээр их хэмжээний бэлэн мөнгөөр хийгдсэн шилжүүлэг,
- Гэр бүл болон бизнесийн холбоогүй гадаад улс оронд илгээсэн хувийн мөнгөн гуйвуулга,

- Цагаачдын мөнгөн гуйвуулгын коридороос гадуур хийсэн мөнгөн гуйвуулга (жишээ нь, Азийн улсаас Өмнөд Америк руу гуйвуулга илгээх),
- Цалин олгогдох хугацаатай холбоогүй өөр цаг хугацаанд илгээсэн хувийн шилжүүлгүүд,
- Харилцагч нь мөнгийг нь тоолсны дараа л ямар дүнг шилжүүлж байгааг мэдэх,
- Харилцагч тухайн шилжүүлэгт гарах зардлыг сонирхдоггүй,
- Харилцагч нь мөнгө илгээх/хүлээн авах улс оронтой ямар нэг холбоогүй бөгөөд яагаад тэндээс мөнгө илгээж/хүлээн авч байгаа талаар хангалттай тайлбарлаж чадахгүй байх,
- Харилцагч нь төлбөр хүлээн авагчийн талаарх мэдээллийг агуулсан тэмдэглэлтэй боловч төлбөрийн зорилгыг дурдах эсэхийг асуухад эргэлзэж байна,
- Хуулийн этгээдийн данс болон хувь хүний данс хооронд их хэмжээний буюу давтан шилжүүлэг хийх, ялангуяа тухайн хувь хүн нь тухайн улсад оршин суудаггүй байх үед,
- Үйлчилгээ үзүүлэгчийн хаяг дээрх гадаад улс оронд байрших компаниудад их хэмжээний мөнгө шилжүүлдэг,
- Их хэмжээний буюу тогтмол мөнгө шилжүүлэх,
- Харилцагчийн бизнестэй нийцэхгүй мөнгөн дүнгээр байнга шилжүүлэг хийх,
- Бүлэг хүмүүсийг ашиглан мөнгө шилжүүлэх,
- Төрөл бүрийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээг ашиглах,
- Илгээсэн мөнгөн дүн нь ердийнхөөс их байх,
- Илгээгч болон хүлээн авагчдын хооронд харилцаа холбоо байхгүй,
- Үйл ажиллагаа нь жигд бус байх,
- Дэлхийн өнцөг булан бүрээс (хөгжилтэй орнуудаас) төрөл бүрийн хүмүүсээс мөнгө хүлээн авах,
- Богино хугацаанд мөнгө хүлээн авах,
- Төрөл бүрийн МҮБЗШҮ үзүүлэгчээс мөнгө хүлээн авах,
- Хүлээн авсан мөнгийг үргэлж бэлнээр гарган авах,
- Нэг хувь хүнээс олон илгээгчид шилжүүлэг хийх.

IX. АВАХ АРГА ХЭМЖЭЭ

9.1 Эрсдэлд суурилсан арга хэмжээ

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь хууль ёсны, зөвшөөрөлтэйгөөр үзүүлж байгаа МҮБЗШҮ-ний эрсдэлийг ФАТФ-аас гаргасан зөвлөмжийн дагуу эрсдэлд суурилсан аргачлалын дагуу үнэлэх шаардлагатай. Ингэхдээ эрсдэлийн үнэлгээ нь шинж чанар, бизнесийн төвөгтэй байдал, санал болгож буй бүтээгдэхүүн үйлчилгээний төрөл, хийгдэх гүйлгээний зорилго, зориулалт, бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх хэлбэр/суваг болон харилцагчдын онцлог зэргийг хамарсан байх шаардлагатай.

МҮБЗШҮ үзүүлэгчид нь үйлчилгээний эрсдэлийг тодорхойлох, удирдах, бууруулах зорилгоор олон төрлийн мэдээллийн эх үүсвэрийг ашиглах хэрэгтэй. Үүнд: ФАТФ болон эрх бүхий байгууллагаас гаргасан зөвлөмж, гарын авлага, типологиуд, шинж тэмдэг, эрсдэлийн үзүүлэлт зэрэг байна. Түүнчлэн эрсдэлийг үнэлэхдээ дараах хүчин зүйлсийг авч үзэх шаардлагатай. Үүнд:

- Харилцагчийнхаа бизнесийн мөн чанар, цар хүрээ, олон талт байдал, нарийн төвөгтэй байдал, зорилтот зах зээлийг ойлгох;
- Өндөр эрсдэлтэй гэж тодорхойлсон харилцагчийн эзлэх хувь хэмжээ;
- МҮБЗШҮ үзүүлэгчийн өөрийн байршдаг эсвэл харилцагчийн үйл ажиллагаа явуулж байгаа эсвэл өөр байдлаар хамаарч байгаа бүс нутгууд, тухайлбал гэмт хэрэг, авлига, терроризмыг санхүүжүүлэх зэрэг янз бүрийн эрсдэлт хүчин зүйлсээс шалтгаалж илүү эмзэг болсон улс орон, түүнчлэн ФАТФ-ын жагсаалтад орсон улс орнууд;
- МҮБЗШҮ үзүүлэгч нь харилцагчтай хэр төвшинд шууд харьцах, ХТМ үйл ажиллагааг хэрхэн явуулах, ХТМ ажиллагаанд гуравдагч этгээдийг ашиглах эсэхийг багтаасан бодлого, мөн харилцагчийн ашиглаж буй төлбөр тооцооны системүүд, технологийн хэрэглээ зэрэг асуудал;
- Дотоод хяналт ба үйл ажиллагааны хэрэгжилтийн дүгнэлт.

Мөн мэдээлэх үүрэгтэй этгээд нь өөрийн байгууллагын хувьд мөнгө угаах гэмт хэрэгт өртөх эрсдэлийг тооцож, арга хэмжээ авах нь тухайн улс орны мөнгө угаах гэмт хэрэгт өртөх эрсдэлд хувь нэмэр болно. Ингэхдээ үндэсний эрсдэлийн үнэлгээ, аюул занал, гэмт хэргийн статистик мэдээлэл, эрх бүхий байгууллагаас гаргасан жагсаалт болон тайлангууд, ФАТФ-аас гаргасан харилцан үнэлгээний тайлангууд, типологийн тайлангууд гэх мэт дотоод болон гадаадын тоон болон чанарын бүхий л мэдээллийг авч үзэх шаардлагатай.

МУТС эрсдэл нь олон төрлийн хүчин зүйлсээс хамаардаг. Гэвч хамгийн түгээмэл эрсдэлийн хүчин зүйлсийг дараах байдлаар авч үзэхийг зөвлөдөг байна. Үүнд:

Бүс нутгийн эрсдэл	Тухайн газар нутагт террорист үйл ажиллагаа явагддаг эсэх, гэмт хэргийн тоон мэдээлэл өндөр байдаг эсэх, хориг арга хэмжээ авагдсан эсэх, ФАТФ-аас МУТСТ тогтолцоо нь сул хөгжсөн гэж тодорхойлсон эсэх гэх мэт хүчин зүйлсийг харгалзан үзэж эдгээр улс оронтой холбоотой хийгдэж буй МҮБЗШҮ болон эдгээр улс орнуудад байрлах МҮБЗШҮ үзүүлэгчидтэй хамтарч ажилладаг өөрийн орны МҮБЗШҮ үзүүлэгчдийн эрсдэлийг тооцох шаардлагатай.
Харилцагчийн эрсдэл	Тухайн харилцагчдын ажил эрхлэлт, зан төлөв болон үйлдлийг харгалзан үзэж эрсдэлийг тогтоох шаардлагатай.
Бүтээгдэхүүн/гүйлгээ/үйлчилгээний эрсдэл	МҮБЗШҮ үзүүлэгчид нь үзүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээний эрсдэлийг тооцох шаардлагатай. Тухайлбал харилцагч нэрээ нууцлах боломжтой бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд болох бэлэн мөнгө, цахим мөнгөн шилжүүлэг, урьдчилсан төлбөрийн картууд /цалингийн, бэлгийн гэх мэт/, гүйлгээний хязгааргүй бүтээгдэхүүн үйлчилгээ, олон улсад санал болгодог бүтээгдэхүүн, үйлчилгээ гэх мэт.
Түгээлтийн эрсдэл/агент эрсдэл	МҮБЗШҮ үзүүлэгчид нь хэрэв хэд хэдэн агентаар дамжуулан үйлчилгээгээ явуулдаг бол эдгээр агентын эрсдэлийг тооцох шаардлагатай. Тухайн агентын байршдаг улс орон, тухайн агентад УТНБЭ-ийн оролцоо байгаа эсэх, бусад агенттай харьцуулахад их хэмжээний гүйлгээ хийх, агенттай холбоотой олон нийтийн мэдээлэл гэх мэт тухайн агентын эрсдэлийг тооцоолох олон хүчин зүйлсийг авч үзэх шаардлагатай.

МҮБЗШҮ үзүүлэгч нь харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хууль журмын дагуу авсан, цуглуулсан мэдээлэлд үндэслэн харилцагчийн эрсдэлийг тодорхойлох, тухайн мөнгө шилжүүлэгч болон хүлээн авагчдын мэдээллийг баталгаажуулан шалгах байдлаар хэрэгжүүлнэ. Үүнд тухайн бизнесийн орчны эрсдэлийн талаарх болон ирээдүйн талаарх мэдээллийг ойлгох нь мөн адил хамаарна. МҮБЗШҮ үзүүлэгчид ХТМ үйл ажиллагааг зохих түвшинд хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд Зөвлөмж 10-д заасны дагуу МҮБЗШҮ үзүүлэгчтэй бизнесийн харилцаа үүсгэхгүй байх, гүйлгээ хийхээс татгалзах, эсхүл аль хэдийн үүссэн бизнесийн харилцааг дуусгавар болгох, сэжигтэй гүйлгээний тайлангаар мэдээлэх зэрэг арга хэмжээ авахыг шаарддаг. Түүнчлэн МҮБЗШҮ үзүүлэгчид нь үргэлжилсэн ХТМ арга хэмжээ болон хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.

9.2 Сэжигтэй гүйлгээг илрүүлэх

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь мөнгөн гуйвуулгын үйлчилгээг ашиглан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үйл олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой гэмт хэрэг үйлдэх, үйлдэхийг завдахаас сэргийлэх зорилгоор эрсдэлд суурилсан аргачлалын дагуу эрсдэлийг тооцох шаардлагатай. Тухайн эрсдэлийн үнэлгээнд тохирсон аргачлалаар хууль ёсны



МҮБЗШҮ-нд хяналт тавих, хууль бус МҮБЗШҮ үзүүлэгчийг илрүүлэх арга хэмжээг тус тус авна.

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь учирч болох эрсдэлээс хамгаалах зорилгоор хууль бус МҮБЗШҮ-г илрүүлэх зайлшгүй шаардлагатай бөгөөд МҮБЗШҮ-г ашиглан үйлдэгдсэн гэмт хэргийн талаарх типологи, кейс болон шинж тэмдгийг авч үзэх шаардлагатай. Тухайн харилцагчийн гүйлгээнд МҮБЗШҮ-г ашиглан гэмт хэрэг үйлдэж байж болзошгүй, энэхүү тайланд дурдсан шинж тэмдэг агуулагдсан эсэхийг шалгах шаардлагатай.

9.3 Сэжигтэй гүйлгээний тайлангаар мэдээлэх

Хэрэв мэдээлэх үүрэгтэй этгээдийн гүйлгээний хяналтаар тухайн гүйлгээ нь энэхүү тайланд дурдсан шинж тэмдэг болон бусад шинж тэмдгийг агуулсан бол харилцагч, гүйлгээг нарийвчлан шалгаж Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ. МҮБЗШҮ-тэй холбоотой сэжигтэй гүйлгээг Сэжигтэй гүйлгээний тайлангаар хууль, журамд заасан маягтын дагуу хуульд заасан хугацаанд Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.